



**НИЙСЛЭЛИЙН
ТӨР ЗАХИРГААНЫ АВТО БААЗ УТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 04 сарын 23 өдөр

Дугаар A/34

Улаанбаатар хот

┌ Тээврийн хэрэгслийг балансаас ┐
└ балансад шилжүүлэх тухай ┘

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 5.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны A/535 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Авто баазын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 35 000 000 /гучин таван сая/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Хьюндай старекс маркийн 81-66УНУ улсын дугаартай, KMJWAN7JP8U078776 арлын дугаартай автомашиныг Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газрын балансад шилжүүлэхээр шийдвэрлэсэн тул үндсэн хөрөнгийн данс бүртгэлээс хасахыг Санхүү төлөвлөлтийн хэлтэс /Б.Үүрцайх/-т зөвшөөрсүгэй.

2.Автомашиныг зохих журмын дагуу акт үйлдэн хүлээлгэн өгч, актыг Нийслэлийн Өмчийн ашиглалт удирдлагын газарт хүргүүлэх, Авто тээврийн Үндэсний төвийн бүртгэлээс хасалт хөдөлгөөн хийлгэхийг Өмч хамгаалах байнгын зөвлөл /М.Сүхбат/-д даалгасугай.

ДАРГА



Ш.НАРАНБААТАР